

БАТЛАВ:

БОАЖЯ-ны ХҮРЭЭЛЭН БУЙ ОРЧНЫ БОДЛОГО ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ДАРГА...../Г.ЭНХМӨНХ/

ЗӨВШӨӨРЧ, ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮҮРЭГ ХҮЛЭЭСЭН:

“ХУР ЭРДЭНЭ БАЯЛАГ” ХХК-ийн ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ...../ДУН ШИАН РУИ/

**ӨМНӨГОВЬ АЙМГИЙН НОЁН СУМЫН
НУТАГТ БАЙРЛАХ “БАРУУН НОЁН УУЛ”
НҮҮРСНИЙ УУРХАЙН 2024 ОНЫ БАЙГАЛЬ
ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ**

/АШИГТ МАЛТМАЛЫН ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ДУГААР-МУ-017301/

/АЖ АХУЙН НЭГЖИЙН РЕГЕСТРИЙН ДУГААР-5671833/

Хянасан:

БОАЖЯ-ны ХБОБЗГ-ын ахлах шинжээч...../Ц.Жаргалнэмэх/

Боловсруулсан:

“Хур Эрдэнэ Баялаг” ХХК-ний байгаль орчны мэргэжилтэн...../Д.Буянзул/

2024 ОН

АГУУЛГА

НЭГ. УУРХАЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА	4
1.1 Төслийн нэр	4
1.2 Төсөл хэрэгжүүлэгч компани	4
1.3 Төслийн байршил	4
1.4. Уурхайн хүчин чадал, ашиглалтын хугацаа	5
1.5. Тэсэлгээний процесс	6
1.6. Уурхайн тээвэр.....	7
1.7. Овоолго байгуулах байршлын сонголт, овоолгын тооцоо	7
1.8. Уурхайн ус таталт	7
1.8.1. Ил уурхайн ус зайлуулах ажил	8
1.9. Зам харилцаа	9
1.10. Уурхайн барилга байгууламжууд	11
1.10.1. Уурхайн хотхон	11
1.10.2. Гаалийн хяналтын бүс.....	14
1.10.3. Шатахуун түгээх станц	14
1.11. Уурхайн усан болон дулаан хангамж	14
1.12. Цахилгаан хангамж	16
ХОЁР. БАЙГАЛЬ ОРЧНЫ ТӨЛӨВ БАЙДАЛ.....	18
2.1. Төсөл хэрэгжих орчны байршил, физик газарзүйн нөхцөл	18
2.2. Нийгэм, эдийн засаг.....	21
ГУРАВ. ТӨСЛӨӨС ҮЗҮҮЛЖ БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛӨЛ	22
ДӨРӨВ. 2024 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ	25
4.1. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө.....	26
4.1.1. Агаар орчны сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө.....	26
4.1.3. Хөрсөн бүрхэвчид учруулж болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө.....	28
4.1.4. Газрын хэвлийд учруулж болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө.....	29
4.1.5. Ургамлын аймаг, ургамлан нөмрөгт учруулж болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө.....	30
4.1.6. Амьтны аймагт учруулах сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө	31
4.2. Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө	32
4.3. Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө.....	34
4.4. Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөө	34
4.6. Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө.....	37
4.7. Хог, хаягдлын менежментийн төлөвлөгөө	38
4.9. Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө	41
4.10. Тухайн жилийн байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөний биелэлтийг нөлөөллийн бүсийн оршин суугчдад тайлагнах төлөвлөгөө	43
4.11. Тэрбум мод үндэсний хөдөлгөөний хүрээнд хийгдэх ойжуулалтын ажил.....	45

ЗУРАГ, ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Зураг 1. Төслийн талбайн байршил.....	4
Зураг 2. Уурхайн гадаад автозамын сүлжээ.....	9
Зураг 3. Гадаад тээврийн замын эхлэл хэсгийн харагдах байдал.....	10
Зураг 4. Уурхайн дотоод автозам.....	11
Зураг 5. Уурхайн хотхоны зураг.....	12
Зураг 6. Албан контор, уурын зуух, лаборатори.....	13
Зураг 7. Зоогийн газар, халуун ус, ариун цэврийн өрөө.....	13
Зураг 8. Ажилчдын амрах гэрүүд.....	13
Зураг 9. Гаалийн хянатын бүсийн байгууламжууд.....	14
Зураг 10. Шатахуун түгээх станц.....	14
Зураг 11. Уурхайн хотхоны худаг, тоолуур суурилуулсан байдал.....	15
Зураг 12. Байгалийн бүс бүслүүр.....	18
Хүснэгт 1. 1. Төслийн товч танилцуулга.....	4
Хүснэгт 1. 2. Тусгай зөвшөөрлийн бүхий талбайн солбилцлын цэгүүд.....	5
Хүснэгт 1. 3. Уурхайн ажиллах горим.....	5
Хүснэгт 1. 4. Уулын ажлын календарчилсан төлөвлөгөө.....	5
Хүснэгт 1. 5. Өрөмдлөг тэсэлгээний ажлын паспорт.....	6
Хүснэгт 1. 6. Тэсрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн хэрэгцээний тооцоо.....	6
Хүснэгт 1. 7. Нүүрс тээвэрлэх зай.....	7
Хүснэгт 1. 8. Усны эх үүсвэрүүдийн үзүүлэлт.....	15
Хүснэгт 1. 9. Жилийн усны хэрэглээ, м3.....	16
Хүснэгт 1. 10. Технологийн усны хэрэглээ.....	16
Хүснэгт 1. 11. Дизель цахилгаан үүсгүүрийн техникийн үзүүлэлт.....	17
Хүснэгт 1. 12. Технологийн усны хэрэглээ.....	17
Хүснэгт 3. 1. Байгаль орчинд үзүүлэх нөлөөллийн хэлбэр үргэлжлэх хугацаа.....	22
Хүснэгт 4. 1. Агаар орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө.....	26
Хүснэгт 4. 2. Усны нөөцөд учруулж болзошгүй сөрөг нөлөөг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө.....	27
Хүснэгт 4. 3. Хөрсөн бүрхэвчид үзүүлж болзошгүй сөрөг нөлөөг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө.....	28
Хүснэгт 4. 4. Ургамлан нөмрөгт учруулж болзошгүй сөрөг нөлөөг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө.....	30
Хүснэгт 4. 5. Амьтны аймагт учруулж болзошгүй сөрөг нөлөөг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө.....	31
Хүснэгт 4. 6. Нөхөн сэргээлтийн арга хэмжээний төлөвлөгөө.....	32
Хүснэгт 4. 7. Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө.....	34
Хүснэгт 4. 8. Нүүлгэн шилжүүлэлт, нөхөн олговрын арга хэмжээний төлөвлөгөө.....	35
Хүснэгт 4. 9. Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө.....	36
Хүснэгт 4. 10. Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө.....	37
Хүснэгт 4. 11. Хог, хаягдлын менежментийн төлөвлөгөө.....	38
Хүснэгт 4. 12. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр.....	39
Хүснэгт 4. 13. Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө.....	41

Хүснэгт 4. 14. Тухайн жилийн байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөний биелэлтийг нөлөөллийн бүсийн оршин суугчдад тайлагнах төлөвлөгөө	43
Хүснэгт 4. 15. 2024 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд зарцуулах нийт зардал	44
Хүснэгт 4. 16. Тэрбум мод үндэсний хөдөлгөөний хүрээнд хийгдэх ойжуулалтын ажлын төлөвлөгөө	46

НЭГ. УУРХАЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

1.1 Төслийн нэр

Өмнөговь аймгийн Ноён сумын нутагт орших “Баруун ноён уул” нэртэй чулуун нүүрсний ордыг ил аргаар ашиглах төсөл.

1.2 Төсөл хэрэгжүүлэгч компани

Төсөл хэрэгжүүлэгч “Хур эрдэнэ баялаг” ХХК нь 2013 онд уул уурхайн олборлолтын үйл ажиллагаа явуулахаар үүсгэн байгуулагдсан Монгол улсын 9019071068 тоот улсын бүртгэлийн дугаартай, 100% БНХАУ-ын хөрөнгө оруулалтай аж ахуйн нэгж юм.


Төсөл хэрэгжүүлэгч нь одоогийн байдлаар MV-17301 тоот ашигт малтмал ашиглах тусгай зөвшөөрлийг эзэмшдэг ба өөр чиглэлээр үйл ажиллагаа явуулаагүй, зөвхөн энэ төсөл дээр төвлөрөн ажиллаж байгаа юм.

Хүснэгт 1.1. Төслийн товч танилцуулга

Үндсэн үзүүлэлтүүд	Тайлбар
Аж ахуйн нэгжийн нэр	“Хур эрдэнэ баялаг” ХХК
Улсын бүртгэлийн дугаар	39019071068
Регистрийн дугаар	5671833
Ашигт малтмалын тусгай зөвшөөрөл	MV-017301
Ашигт малтмалын тусгай зөвшөөрөл олгосон огноо	2013.04.17
Ашиглалтын талбай	1085.2 га
Хаяг	Өмнөговь аймаг, Ноён сум хот, Сайран баг, Цагаан дэрс

1.3 Төслийн байршил

“Баруун ноён уул” нэртэй MV-017301 тоот ашиглалтын тусгай зөвшөөрөл бүхий талбай нь Өмнөговь аймгийн Ноён сумын нутагт бөгөөд Улаанбаатар хотоос 780 км, Өмнөговь аймгийн төв Даланзадгад хотоос баруун тийш 210 км, Ноён сумын төвөөс зүүн тийш 30 км зайд оршино.



Зураг 1. Төслийн талбайн байршил

Хүснэгт 1. 2. Тусгай зөвшөөрлийн талбайн солбилцлын цэгүүд

№	Уртраг	Өргөрөг
1.	102 ⁰ 23' 4.9"	43 ⁰ 6' 0.26"
2.	102 ⁰ 23' 4.9"	43 ⁰ 5' 29.58"
3.	102 ⁰ 30' 0.89"	43 ⁰ 5' 29.58"
4.	102 ⁰ 30' 0.89"	43 ⁰ 5' 1.29"
5	102 ⁰ 22' 0.8"	43 ⁰ 5' 1.31"
6	102 ⁰ 22' 0.8"	43 ⁰ 6' 0.26"

1.4. Уурхайн хүчин чадал, ашиглалтын хугацаа

2022 оны эцсийн байдлаар төсөл хэрэгжүүлэгчийн техникийн чадамж нь жилд 3000.0 мян.м³ уулын цул гаргах боломжтой байна.

2023 онд төсөл хэрэгжүүлэгч нь техникийн хүчин чадлаа нэмэгдүүлж жилд 8.2 сая м³ уулын ажил явуулах боломжтой болж байна.

Уурхайн хүрээ хязгаарт багтсан нөөцийг энэ хүчин чадлаар 2 жилийн хугацаанд ашиглах боломжтой байна.

Уурхай нь одоогийн байдлаар 14/14 хоногийн уртын ээлжинд бүрэн шилжиж өдөр, шөнө 12 цагаар үргэлжлэх 2 ээлжээр ажиллаж байна. Ээлжинд цэвэр ажлын 10 цаг ажиллах буюу цаг ашиглалтын коэффициент 0.83 байна.

Жилд баяр ёслол, амралтын өдрүүд, төлөвлөгөөт засвар, цаг агаарын болзошгүй саатлаас шалтгаалж цэврээр 330 хоног ажиллахаар ТЭЗҮ-д тооцоолсон.

Хүснэгт 1. 3. Уурхайн ажиллах горим

№	Үзүүлэлт	Нэгж	Утга
1	Хуанлийн хоногийн тоо	хоног	365
2	Баяр ёслол, сул зогсолт	хоног	35
3	Жилд ажиллах өдрийн тоо	хоног	330
4	Ээлжийн үргэлжлэх нийт хугацаа	цаг	12
5	Хоногт ажиллах ээлжийн тоо	ээлж	2

№	Үзүүлэлт	Нэгж	Утга
1	Ээлж хүлээлцэж, наряд авах	мин	20
2	Хоолны цаг	мин	60
3	Ээлжийн дэх сул зогсолт	мин	40
4	Ээлжийн үргэлжлэх нийт хугацаа	цаг	12
5	Ээлжийн цэвэр ажиллах цаг	цаг	10
6	Хоногт ажиллах цаг	цаг	20
7	Ээлжийн цаг ашиглалт	%	83.3
8	Жилд ажиллах цэвэр ажлын цаг	цаг/жил	6600

Уурхайд ажиллах тоног төхөөрөмжүүдийн хүчин чадалд үндэслэн бүрэн хүчин чадлаар ажиллах үед жилд 7.5 сая м³ хөрс хуулж, 1000.0 мян.тн нүүрс олборлон 2 жилийн хугацаанд одоо байгаа нөөцийг олборлохоор ТЭЗҮ-д тооцоолсон. Дараах хүснэгтэнд Баруун ноён уул нүүрсний ордын календарчилсан төлөвлөгөөг харуулав.

Хүснэгт 1. 4. Уулын ажлын календарчилсан төлөвлөгөө

№	Үзүүлэлт	Хэм.нэгж	Төслийн жил		Нийт
			1	2	
1	Хөрс хуулалт	мян.м ³	7566	6305.0	13871.0
2	Нүүрс олборлолт	мян.м ³	537.0	740.7	1277.7
3		мян.тн	724.9	1000	1724.95

Өмнөговь аймгийн Ноён сумын нутагт байрлах “Баруун ноён уул” уурхайн 2024 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөө

4	Уулын цул	мян.м ³	8103.0	7045.7	15148.7
5	Хөрс хуулалтын коэффициент	м ³ /тн	10.4	6.3	8.0

1.5. Тэсэлгээний процесс

Тэсэлгээний ажлыг нонель систем ашиглан, цооног хооронд хором удаашралтайгаар туслан гүйцэтгэгч компани явуулж байна. Тэсрэх бодисын агуулах байхгүй. Хуурай цооногийг энгийн найрлагат АНФО, устай нөхцөлд эмульсийн тэсрэх бодис ашиглан явуулж байна.

Өрөмдлөг тэсэлгээний ажлыг дараах тойм паспортын дагуу явуулна.

Хүснэгт 1. 5. Өрөмдлөг тэсэлгээний ажлын паспорт

№	Үзүүлэлт	Нэгж	Тооцооны	Бодит			Тооцооны		
1	Өрмийн машин		Airwellte YS-940B			Kaishan KT 15C			
2	Цооногийн налуу	градус	90	90	90	90	90	90	
3	Тэсрэх бодис		АНФО	АНФО	Эмульс	АНФО	АНФО	Эмульс	
4	Тэсрэх бодисын нягт	кг/м ³	850	850	1050	850	850	1050	
5	Цэнэгийн диаметр	м	0.127	0.127	0.110	0.165	0.165	0.165	
6	Доголын өндөр	м	10	10	10	10	10	10	
7	Улны хамгийн бага эсэргүүцлийн шугам	м	3.8	4.0	4.0	5.0	5.0	5.0	
8	Цооног хоорондын зай	м	4.2	4.0	4.0	5.0	5.0	5.0	
9	Эгнээ хоорондын зай	м	3.8	4.0	4.0	5.0	5.0	5.0	
10	Илүү өрөмдлөгийн гүн	м	1.1	1.0	1.0	1.5	1.0	1.0	
11	Түгжээсний урт	м	2.86	3.00	3.00	3.71	3.50	3.50	
12	Цооногийн урт	м	11.14	11.00	11.00	11.49	11.00	11.00	
13	Цэнэгийн урт	м	8.29	8.00	8.00	7.77	7.50	7.50	
14	1 цооногт орох цэнэгийн хэмжээ	кг	89.2	86.1	79.8	141.2	136.2	168.3	
15	Нэг м цооногт орох ТБ-ийн жин	кг	10.8	10.8	10.0	18.2	18.2	22.4	
16	ТБ-ийн тооцооны хувийн зарцуулалт	кг/м ³	0.56	0.54	0.50	0.58	0.55	0.68	
17	1м цооногоос гарах уулын цул	м ³ /м	14.38	14.55	14.55	21.33	22.50	22.50	
5. Тэсэлгээний аюултай бүсүүд									
18	Шидэлтийн аюултай бүс (хүнд)	м	300	500	500	300	500	500	
19	Шидэлтийн аюултай бүс (т.төх)	м	150	300	300	150	300	300	
20	Цохилтын аюултай бүс (хүнд)	м	650	650	650	650	650	650	
21	Цохилтын аюултай бүс (т.төх)	м	500	500	500	500	500	500	
22	Чичиргээ доргионы аюултай бүс	м	1000	1000	1000	1000	1000	1000	

Тэсэлгээний блокийн хэмжээс янз бүр байна. Төслийн жилүүд дэх тэсрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн хэрэгцээний тооцоог дараах хүснэгтээр үзүүлэв. Нийт тэслэх хөрсний 70%-ийг хуурай, 30%-ийг устай нөхцөл гэж үзэж тооцоог гүйцэтгэв.

Хүснэгт 1. 6. Тэсрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн хэрэгцээний тооцоо

№	Үзүүлэлт	Хэм.нэгж	Төслийн жил		Нийт
			1	2	

Өмнөговь аймгийн Ноён сумын нутагт байрлах “Баруун ноён уул” уурхайн 2024 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөө

1	Тэслэх хөрс		мян.м ³	7566.3	6304.5	13870.9
2	Тэслэгээний блокийн дундаж хэмжээс	Блокийн эзлэхүүн	мян.м ³	160	160	320.0
3		Өрөмдлөгийн хэмжээ	мян.м	11	11	22.0
4		Эгнээний тоо	шир	8	8	
5		Эгнээн дэх цооногийн тоо	шир	125	125	
6		Цооногийн тоо	шир	1000	1000	2000.0
Тэсрэх бодис, тэслэгээний хэрэгслийн зарцуулалт						
7	Тэсрэх бодис	АНФО - 70%	тонн	2850.0	2200.7	5050.7
8		Эмульс - 30%	тонн	1221.4	943.2	2164.6
9	Тэслэгээний хэрэгсэл	Цооногийн цэнэг өдөөгч (Booster)	шир	49653.9	41373.6	91027.5
10		Нонель хором удаашруулагч	мян.м	47.3	39.4	86.7
11		Эгнээ хооронд хором удаашруулагч - 42мс, 8м	шир	5911	4925	10836.6
12		Цооног хооронд хором удаашруулагч - 67мс, 12м	шир	49653.9	41373.6	91027.5

1.6. Уурхайн тээвэр

Ил уурхайн хөрсийг уурхайн хөрсний гадаад овоолгод байршуулна. Хөрс тээвэрлэлтийн дундаж зай 1.4 км, нүүрс зай тогтмол 1.2 км байна. Ашиглалтын жил бүрийн хөрс, нүүрс тээвэрлэлтийн зайг дараах хүснэгтэд үзүүлээ.

Хүснэгт 1. 7. Нүүрс тээвэрлэх зай

Ашиглалтын жил	Хөрс тээврийн зай, км	Нүүрс тээврийн зай, км
1	1.4	1.2
2	1.8	1.2
Дундаж	1.6	1.2

1.7. Овоолго байгуулах байршлын сонголт, овоолгын тооцоо

Ордын геологийн тогтоцоос хамараан хөрсний дотоод овоолго байгуулах боломж муу, гадаад овоолго байгуулан ажиллаж байна. Хөрсний гадаад овоолгыг уурхайн карьерийн урд талд, урд амсраас Овоолгын хамгийн доод буюу суурь ярусыг гадаргын өндөржилтөөс хамааруулан 20 м хүртэл өндөртэй байхаар төлөвлөн тэлж хэлбэржүүлсэн нь одоогийн байдлаар 26.5 га талбайг хамарч, дээд 20 м өндөртэй ярус нь 10.2 га талбайг дүүргэж, нийт 4.0 сая м³ эзлэхүүнтэй болжээ. Уурхайн 2 дахь жилийн байдлаар 80м өндөртэй 4 ярустай нийт 38.0 га талбайг эзэлнэ.

” Уурхайн үйл ажиллагаанд өртөх уурхайн олборлолтын талбай, овоолгын доод хэсэг, барилга байгууламж, замын өнгөн хэсгийн шимт хөрсийг уурхайн үйл ажиллагаа эхлэхээс өмнө хуулан, тусгайлан зассан овоолгод байршуулна. Элс, элсэнцэр зэрэг ургамал ургах боломжтой шимэрхэг хөрс, бусад тохиромжтой хөрсийг 0.2 м хүртэл гүнд хуулж авна. Уурхайн нөхөн сэргээлтийн ажилд шимт хөрсийг эргүүлэн ашиглана.

Овоолго байгуулахад талбайн ашиглалтад их анхаарах бөгөөд овоолгын ул сууринд гулсамтгай чулуулгийн үе байгаа эсэхийг судалж, байгаа бол зайлуулах, бэхжүүлэх арга хэмжээ авна.

1.8. Уурхайн ус таталт

Уурхайн үйл ажиллагааг хэвийн, тасралтгүй, найдвартай явуулахад ил уурхайд орж ирэх усыг зайлуулах, нүүрсий үе, давхраас, уурхайн мөрөгцгийг хуурайшуулах, шүүрүүлэх ажлыг

зайлшгүй гүйцэтгэнэ. Иймд ордын газар доорхи усны хэмжээ, энэ нь уурхайд хэрхэн нөлөөлөх, агаарын хур тунадас, шар усны үерээс орж ирэх усны тооцоог зайлшгүй тодорхойлно.

1.8.1. Ил уурхайн ус зайлуулах ажил

2023 оны 03 дугаар сард хийгдсэн гидрогеологийн судалгаагаар ил уурхайд орж ирэх усны тоо хэмжээ, тооцоог тодорхойлохдоо геологийн тогтоц, гидрогеологийн нөхцөл зэрэг байгалийн болон уул-техникийн олон хүчин зүйл дээр тулгуурлажээ. Үүнд:

- Ил уурхай байгуулах ойр орчимд гол, мөрөн, горхи, булаг зэрэг урсгал ус, нуур, цөөрөм зэрэг тогтмол ус байгаа эсэх
- Хүчтэй усжилт бүхий тектоникийн том хагарал, тохрол, өргөгдөл, суулт, шохойн чулууны карст, шатсан чулуу, олон жилийн цэвдгийн онцлог байдал
- Газрын гадаргуугийн хотгор, гүдгэрийн хэв шинж, хэрчигдэлд орсон байдал
- Газрын доорхи усны тэжээгдлийн муж, түүний тархалтын талбай, уст давхаргын шинж чанар, даралттай, даралтгүй ус, тэдгээрийн хил, заагийн нөхцөл, хоорондын холбоо гэх мэт олон төрлийн зүйлээс хамаарна.

Баруун ноён уулын уурхайн талбай, түүний ойр орчмын газрын гадаргуу нь хэрчигдэлд зарим газраа нилээд орсон ба гадаргуугийн хотгор, гүдгэрийн эрс ялгаа байхгүй боловч жижиг дов толгод нилээд тохиолдоно.

Карбоны настай нүүрсний үе, давхраасууд нь ус агуулагч бөгөөд сул цементлэгдсэн, ан цавархаг элсэнчулуу, гравелиттай хамт нэгэн уст цогцолборыг үүсгэж, бага зэргийн даралттай шинжийг хадгалах ба газар доорхи усны түвшин хайгуулын цооногуудад (BHN017-р цооног)-25.0 м-т, (BHN032-р цооног)-16.8м-т, (BHN034-р цооног)-20.5м-т, (BHN027-р цооног)-12.8м-т, гидрогеологийн цооногт 12.10-29.21м-т харилцан адилгүй байдаг. Нүүрсний үе, давхраасууд нь моноклиналь тогтоцтой, харьцангуй бага гүнд байрлах боловч 25-300-ын уналтай ба геологи, тектоникийн тогтоц нь нилээд нийлмэл бүтцийг үүсгэнэ. Усжилт бүхий тектоникийн хагарал, ан цав нилээд элбэгтэй, тохрол, өргөгдөл, суултанд орж олон блокт хуваагдсан байна. Ул суурийн хурдас нь уст үе, давхарга багатай шаварлаг хурдас тухайлбал хар, хар саарал өнгийн аргиллит, алевролит, алевро-элсэнчулуу, шаварлаг болон тогтох ба усжилт бага байдаг онцлогтой. Ордын гидрогеологийн нөхцлийн хувьд дээрх хүчин зүйлүүд “энгийн” нөхцөлтэй ангилалд оруулах боломжийг бүрдүүлж байна.

” ” ” ”

Ил аргаар ашиглах нөхцөлд уурхайд орж ирэх усны хэмжээг гидродинамикийн арга дээр тулгуурлан “Их худгийн” томъёогоор тодорхойлсон байна.

$$Q = \frac{\pi k H^2 S}{\mu} \left(1 - \frac{r^2}{R^2} \right) \left(1 - \frac{r^2}{4kt} \right)$$

k - шүүрэлтийн итгэлцүүр, 3.88м/хоног,

m - уст үеийн зузаан, 19.0м

R - ил уурхайн нөлөөллийн радиус, 9653.7м.

Уурхайн нөлөөллийн радиусыг доорх томъёогоор тооцжээ.

t - уурхайн ус таталт үргэлжлэх хугацаа 1895 хоног.

μ - ус өгөмжийн итгэлцүүр, 0.003

Ус өгөмжийн итгэлцүүрийг уст үеийн шүүрэлтийн итгэлцүүрээс хамааруулж тодорхойлдог. Манай нөхцөлд Ф.М. Бочеверын зөвлөмжийн дагуу түрэлтэт нөхцөлд ан цавлаг чулуунд 0.003 байна.

r - ил уурхайн радиус (том худгийн радиус),м

Ил уурхайн радиусыг тооцвол


$$r = 0.565 \sqrt{F} = 0.565 \sqrt{192.5 \text{ мян.м}^2} = 247.9 \text{ м}$$

F - ордын талбай, 192.5 мян.м²

1.9. Зам харилцаа

Уурхайн талбайгаас Ноён сумын төв болон Шивээхүрэн боомт руу хүрэх сайжруулсан шороон замуудыг зэргэлдээх “Терра Энержи” ХХК байгуулсныг бусад уурхайнууд болон иргэд, байгууллагууд ашигладаг.

Төсөл хэрэгжүүлэгч “Хур Эрдэнэ Баялаг” ХХК нь тус уурхайн талбайгаас энэхүү сайжруулсан шороон зам хүртэл 9 км замыг 2020 оны III улиралд хусаж тэгшлэн хазгай налууг тэгшлэн болон хөтөл гүвээний зорчих хэсгийг өргөн болгох зэргээр замын аюултай хэсгүүдийг засаж янзлан тогтмол арчилж тордож байна.



Зураг 2. Уурхайн гадаад автозамын сүлжээ

Өмнөговь аймгийн төв Даланзадгад хотыг Сэврэй, Гурвантэс сумдтай холбох улсын чанартай хатуу хучилттай автозамын бүтээн байгуулалтын ажил үргэлжлэн явагдаж 2022 оны эцсийн байдлаар төслийн талбайгаас 70 км зайд ирээд байна. Энэхүү хатуу хучилттай зам нь талбайгаас хойд зүгт шулуунаар 50 км зайтай өнгөрөхөөр байгаа нь цаашид тус уурхайн зам харилцаанд ихээхэн ач холбогдолтой болох юм. Уурхайн ажилчдыг тээвэрлэх, бараа материал, хүнс зэргийг татан авах шаардлагаар аймгийн төв Даланзадгад хот цаашлаад Улаанбаатар хот руу энэхүү замаар зорчих таатай нөхцөл бүрдэнэ.

Экспортод гаргаж буй нүүрсний тээврийг худалдан авагч тал хариуцаж “Терра Энержи” ХХК-ийн бүтээн байгуулсан 120 км сайжруулсан шороон замаар тээвэрлэн Шивээхүрэн боомтоор дамжуулан БНХАУ-д экспортолдог. Энэ замыг төсөл хэрэгжүүлэгч

ашигласны төлбөрийг эдийн засгийн тооцоонд тусгасан. 2020 оны II улиралд төсөл хэрэгжүүлэгч нь өөрийн экспортын талбайгаас дээрх гадаад тээврийн зам хүртэл 5.2 км урттай, үерийн усны 2 гүүрэн хоолой, далан бүхий сайжруулсан шороон зам байгуулан ашиглаж байна.



Зураг 3. Гадаад тээврийн замын эхлэл хэсгийн харагдах байдал

Уурхайн технологийн дотоод замуудыг 20 м өргөнтэй тусгаарлах далан хөмсөгтэйгээр байгуулан дотоод хэрэгцээнд ашиглаж байна. ТЭЗҮ-ийн тодотголын хүрээнд уурхайн карьер, хөрсний гадаад овоолгын тэлэлт зэргийг харгалзан одоо байгаа технологийн замуудыг аль болох хадгалах зарчмаар төлөвлөн зурагт буулгав. Уурхайн кемп, уурхайн эдэлбэр талбайн хооронд нийт дотоод хэрэгцээний 7.2 км замыг 9.8 км болгон уртасгахаар төлөвлөв.





Зураг 4. Уурхайн дотоод автозам

1.10. Уурхайн барилга байгууламжууд


Тусгай зөвшөөрөл бүхий нийт 1085.4 га талбайд хоёр хэсэг газарт 264.0 га уурхайн эдэлбэр болон уурхайгаас зүүн зүгт 4.2 км зайд байршилтай уурхайн хотхон 5.га талбайд газар ашиглах зөвшөөрөл авч үйл ажиллагаа явуулж байна. Уурхайн хотхоны хашаан дотор засварын газар, уурхайн эдэлбэр талбайн урд хэсэгт ШТС, баруун захад гаалийн хяналтын бүс тус тус байрлаж байна.

1.10.1. Уурхайн хотхон

Манай компани 2014 онд уурхайн хотхоны эхний барилга байгууламжуудыг барьж эхэлжээ.

Хотхоны бүрэлдэхүүнд 480 м² хурлын зал, эмнэлгийн өрөө, уурын зуух бүхий албан контор, нүүрс шинжлэх лаборатори, ажилчдын амрах гэрүүд, 250 м² засварын цех, авто зогсоол, унд ахуйн худаг, харуулын байр, зочдын гэр, хогийн төрөлжсөн цэг, 132 м² ариун цэврийн байгууламж, халуун ус, хоолны газар зэрэг багтана.

Хотхоныг бүхэлд нь 900 м төмөр тороор хашаалан хайлаас, улиас, жигд, сухай зэрэг 9 төрлийн 2000 мод, бут суулган ургуулж байна.



Зураг 5. Уурхайн хотхоны зураг



Зураг 6. Албан контор, уурын зуух, лаборатори




Зураг 7. Зоогийн газар, халуун ус, ариун цэврийн өрөө



Зураг 8. Ажилчдын амрах гэрүүд

1.10.2. Гаалийн хяналтын бүс

Төсөл хэрэгжүүлэгч “Хур Эрдэнэ Баялаг” ХХК нүүрс ачиж буулгах Гаалийн хяналтын бүсийг 2020 оны IV улиралд бүрэн ашиглалтанд оруулж Шивээхүрэн дэх гаалийн газарт бүртгүүлэн албан ёсны үйл ажиллагааг 2021 оны I улирлаас эхлүүлсэн. Гаалийн хяналтын бүс нь одоогийн байдлаар 8.3 га талбайг эзэлж задгай болон чингэлэг тээврийн 2 пүү, хучлагын байгууламж, өндөр хурдны интернетэд холбогдсон мэдүүлэгчийн байр зэрэг барилга байгууламжуудтай, 24 цагийн камерийн хяналтын системээр тоноглогдсон байна.



Зураг 9. Гаалийн хяналтын бүсийн байгууламжууд

1.10.3. Шатахуун түгээх станц

Өнөөдрийн байдлаар 50 м³ багтаамж бүхий 4 савтай ШТС-ийг ашигладаг ба 2021 онд 79.2 сая төгрөгөөр нүүлгэн шилжүүлж одоогийн байршилд суурилуулсан. ШТС нь аваарын систем, цэнэглэх талбай, зориулалтын хашлага, аянга зайлуулах систем, гэрэлтүүлгээр тоноглогдсон.



Зураг 10. Шатахуун түгээх станц

1.11. Уурхайн усан болон дулаан хангамж

Нүүрсний уурхайн талбайд 2023 онд “Буурцагт алмаз” ХХК-ийн гүйцэтгэсэн гидрогеологийн судалгааны ажлын үр дүн, уурхайд орж ирэх усны тооцоогоор хамгийн ихдээ

хоногт 1206.5 м³ ус шүүрч орж ирэхээр байна. Технологийн усны хэрэгцээ хоногт 1105.6 м³ тул үүнийг шүүрлийн уснаас хангах бүрэн боломжтой байна.

Уурхайн хотхонд 2019 оны 09 сарын 01-нд 60 м гүнтэй худаг усны мэргэжлийн байгууллагаар өрөмдүүлж, шавхалтыг хийж 1 л/с ундарга тодорхойлуулан QS-100-0.75-80-3 маркын насос суурилуулжээ. Мэргэжлийн хяналтын газрын Сорилтын лабораторийн шинжилгээний 2019 оны 09 сарын 10-ны өдрийн дүнгээр усны үзүүлэлт шаардах хэмжээний дотор байгаа болохыг тодорхойлжээ. Энэ худгаас унд, ахуйн хэрэгцээ, уурын зуухны эргэлтийн усыг хангаж байна.

Унд ахуйн хэрэгцээний усны шинжилгээг жилд 3-4 удаа мэргэжлийн хяналтын байгууллага бусад мэргэжлийн лабораториудад хийлгэж байна.



Зураг 11. Уурхайн хотхоны худаг, тоолуур суурилуулсан байдал

Уурхайн карьерын зүүн талд 2021 оны 01 дүгээр сарын 18-нд 110 м гүнтэй цооног усны мэргэжлийн байгууллагаар өрөмдүүлж, шавхалтыг хийлгэн ундаргыг тодорхойлуулахад 1 л/с гэж тодорхойлсон байна.

Хүснэгт 1. 8. Усны эх үүсвэрүүдийн үзүүлэлт

№	Эх үүсвэр	Ундарга л/с	Худгийн хүчин чадал, м ³		
			цагт	хоногт	жилд
1	Уурхайн худаг	1	3.6	79.2	26136
2	Кемпийн худаг	1	3.6	79.2	26136
3	Шүүрлийн ус	14	50.4	1209.6	399168
	Нийт	3	57.6	1368	451440

Шаардлагатай технологийн ус хангамжид гадаад, дотоод зам, талбайн тоос дарах усалгаа, ногоон байгууламж, хотхоны зам талбайн болон зарим тохиолдолд тоног төхөөрөмжүүдэд хэрэглэх усны хэрэглээг багтаав. Өвлийн улиралд 7 хоногт 2-3 удаа, бусад үед хоногт 4 удаа услахаар тооцов.

Нэг хүний хоногийн хэрэгцээний усыг Байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуулчлалын сайдын 2015 оны 07 дугаар сарын 30-ны өдрийн А/301 дугаар тушаалын 12 дугаар хавсралтыг

үндэслэн 53 л, мөн тушаалын 13 дугаар хавсралтад “Зүлэгжүүлэлт, зам талбайн усалгааны норм”-д 1 ширхэг модонд 4 л, “Технологийн хэрэглээ буюу зам талбайн усалгаа”-нд 1 м² талбайд 2 л гэж заасныг баримтлан тооцлоо.

Уурхайд нэг хоногт нийт 168 хүн ажиллах тул унд ахуйн хэрэгцээнд жилд дунджаар 2648.0 м³, зам талбай услах ажилд дулааны улиралд хоногт 4 удаа, хүйтний улиралд 7 хоногт 2-3 удаа буюу хоногт 256.9 м³ хэрэглэхээр тооцоолоход жилд дунджаар 322552.0 м³ ус хэрэглэхээр байна.

Усан хангамжийн түгээлтийг унд ахуйн хэрэглээ дотоод шугам сүлжээгээр, технологийн усыг БНХАУ-д үйлдвэрлэгдсэн Dongfeng DFAC загварын 20 тн-ийн багтаамжтай 2, ба 10 тн багтаамжтай 1 усны машинаар хангахаар төсөлд тусгасан.

Хүснэгт 1. 9. Жилийн усны хэрэглээ, м³

№	Зориулалт	Хэрэглээ, м ³	
		1 дэх жил (2024)	2 дахь жил (2025)
1	Унд, ахуйн хэрэглээ	2325.1	2970.6
2	Технологийн ус	283239.2	361864.8
	дүн	285564.3	364835.4

Хүснэгт 1. 10. Технологийн усны хэрэглээ

Төрөл	Услах мод, ш, талбай, м ²	Жилд услах хоног		хоногт услах тоо		Зарцуулалтын норм, литр	Усны хэрэглээ, м ³	
		өвөл	бусад	өвөл	бусад		Хоногт /дулаанд/	Жилд
Тоос дарах	135820	110	205	0.3	4	2	1086.56	231708.9
Ногоон байгууламж	5000	0	205	0	0.5	4	10	2050
Тоног төхөөрмж								10.0
Нийт							1096.56	233768.9

Жилийн ажлын үргэлжлэх хугацаа дулааны улиралд 330 хоног тул захиргаа аж ахуйн байр, хоолны газар, ариун цэврийн байгууламж зэргийг тус тусын уурын зуухаар, ажилчдын амрах байр гэрүүдийг ердийн галлагаагаар шаардлагатай үед дулаан хангамжийн асуудлыг шийдвэрлэнэ.

1.12. Цахилгаан хангамж

“Баруун ноён уул” нүүрсний орд нь Монгол орны өмнөд бүсэд орших ба цахилгаан эрчим хүчний сүлжээнд холбогдоогүй байна. Ийм учир төслийн цахилгаан хангамжийг бие даасан байдлаар шийдвэрлэжээ.

Уурхайн үндсэн хэрэглэгчийг одоогоор цахилгаанаар хангаж буй эх үүсвэр нь:

1. Ил уурхайд зөөврийн гэрэлтүүлэг
2. Захиргаа, аж ахуй, кемп, засварын газарт дизель станц
3. Гаалийн баталгаат талбайд дизель станц
4. ШТС-д жижиг цахилгаан үүсгүүр

Өмнөговь аймгийн Ноён сумын нутагт байрлах “Баруун ноён уул” уурхайн 2024 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөө

Хүснэгт 1. 11. Дизель цахилгаан үүсгүүрийн техникийн үзүүлэлт

№	Генераторын үзүүлэлт	35КВТ	50	100
1	Хөдөлгүүрийн марк	ZH4100ZD, K4100D	ZH4105ZD, YC4D85Z-D20	R6105AZLD
2	Цилиндрийн тоо	4	4	6
3	Морторын эргэлт	1500rpm	1500rpm	1500rpm
4	Хүчдэл	50Hz	50Hz	50Hz
5	Хүчин чадал, кВт/кВа	30/37.5	50/75	100/125
6	Хувьсах гүйдэл	90А	90А	180А
7	Ороомог	зэс, 220в-400в	зэс, 220в-400в	зэс, 220в-400в
8	Асаалтын систем	стартер	стартер	стартер
9	Хийн оролт			турбинтэй
10	хөргөх систем	усан	усан	усан
11	шатахууны савны хэмжээ			130л
12	Түлш зарцуулалт	1л	2л	7л/цаг
13	Үйлдвэрлэсэн улс	БНХАУ	БНХАУ	БНХАУ
14	Овор хэмжээ,мм	1600×650×1000	1700×650×1150	2300×920×1500
15	Жин, кг	550	750	1250


Хүснэгт 1. 12. Технологийн усны хэрэглээ

Төрөл	Услах мод, ш, талбай, м ²	Жилд услах хоног		хоногт услах тоо		Зарцуулалтын норм, литр	Усны хэрэглээ, м ³	
		өвөл	бусад	өвөл	бусад		Хоногт /дулаанд/	Жилд
Тоос дарах	135820	110	205	0.3	4	2	1086.56	231708.9
Ногоон байгууламж	5000	0	205	0	0.5	4	10	2050
Тоног төхөөрмж								10.0
Нийт							1096.56	233768.9

ХОЁР. БАЙГАЛЬ ОРЧНЫ ТӨЛӨВ БАЙДАЛ

2.1. Төсөл хэрэгжих орчны байршил, физик газарзүйн нөхцөл

Өмнөговь аймгийн Ноён сум нь Монгол орны физик газарзүйн мужлалаар газрын гадаргын хувьд Алтайн уулархаг их мужийн Говийн-Алтайн мужид багтдаг. Төслийн нутаг дэвсгэрт Эхэн хайлааст уул (1873м), Дэнгийн нуруу (1975м), Дөрвөлжин уул (1612м)-с орших бөгөөд талбайн ойролцоох уулс толгод нь д.т.дээш 1600-1900м, мөн Гурвантэс-Борзонгийн говийн элсний мужид хамаарагдах Жарангийн элс байрлана. Уулсын онцлог нь гүн сайраар нилээд хэрчигдсэн, маш эгц хажуутай, харьцангуй тэгш хэмт байдалтай юм. Уулсаас эх авсан сайрууд нь хуурай зарим хэсэгтээ овоо өргөн бөгөөд урт нь хэдэн км-ээс хэдэн арван км хүрнэ.



Зураг 12. Байгалийн бүс бүслүүр

Аймгийн нутаг нь говь цөлийн мужид багтах бөгөөд дунджаар далайн түвшнээс дээш 1300-1600 м өндөрт оршино. Энд Алтайн нурууны үргэлжлэл Гурвансайхан, Сэврэй, Ноён богд, Номгон, Тост, Нэмэгт, Алтан уул, Гилбэнт зэрэг далайн түвшнээс дээш 3000 м хүртэл өндөр өргөгдсөн уул нурууд болон 100 гаруй км үргэлжилсэн Хонгорын элс, хэдэн 100 км өргөн Галба, Борзон, Зээмэг, Заг, Сүүжийн алдарт их говиуд бий.

Тус орд нь нутаг дэвсгэрийн мужлалын хувьд Алтайн уулархаг мужийн Говь-Алтайн мужийн Говь-Алтайн зүүн тойрогт багтдаг.

Олборлолтын талбай нь Эхэн Хайлаастын синклиналийн баруун хойт хэсэгт байрших ба нүүрсний давхраас агуулагч дээд пермийн Дэлийн шанд формацын хурдас нь хойт хэсгээрээ дунд-дээд карбоны Тост формацын андезит-базальтаас тогтох эффузив зузаалаг болон түүнийг зарим хэсгээрээ тасалдалтайгаар хучих доод пермийн Тогоот хар формацын риолит, риодацитаас тогтох хүчиллэг зузаалаг дээр угаагдлын гадаргуугаар хилэлдэг болно. Дэлийн шанд формац хайгуулын талбайн энэ хэсэгт бараг бүхэлдээ дээд дөрөвдөгч-орчин үеийн сэвсгэр хурдсаар хучигдах боловч гуу жалгаар хэрчигдэж идэгдсэн хэсгийн хоёр захаар байнга ил гардаг гаршийн уналын азимут нь $170-200^{\circ}$, налууугийн өнцөг нь $35-40^{\circ}$ байна.

Уул зүй

Тус ордын талбай нь газрын гадаргын хувьд Говь-Алтайн уулсын дундах тал хээрийн бүсэд орших ба ихэнх хэсэг нь бэсрэг уулс толгодорхог гадаргуутай газруудыг хамарна. Талбайн хамгийн өндөрт өргөгдсөн цэг нь талбайн хойд хэсэгт карьерын зүүн хойно орших далайн түвшнээс дээш 1703 м өндөрт өргөгдсөн уулын орой болно. Хамгийн нам цэг нь далайн түвшнээс дээш 1560 м өндөртэй талбайн зүүн өмнөд хэсэг дэх жалга болно.


Ус зүй

Ус зүй, гадаргуугийн усан сүлжээний хувьд Төв Азийн гадагш урсгалгүй ай савд багтдаг бөгөөд тогтмол урсацтай гол горхи, нуур, цөөрөм байхгүй гадаргын ус ховортой бүсэд багтана. Энд зөвхөн уулс хоорондын хотгорт жижиг шал, тойром бүхий газарт хур бороо ихтэй үед уулсын жижиг ам, хөндий хуурай сайраар түр зуурын урсац бүхий ус урсаж хотгоруудын ёроолд хурж тогтох ба сэвсгэр хурдсан доогуур шурган замхардаг.

Талбайн хэмжээнд байнгын урсгалтай гол горхи бараг байхгүй боловч зарим үедээ усны ажиллагаа нилээд идэвхждэг болохыг гэрчлэх ор мөр цөөнгүй бий. Талбайд уртрагийн дагуу чиглэлтэй голын хуурай сайр түүнд цутгах жижиг сайрууд, хэрчигдэл багатай хөндийнүүд хөгжсөн байна. Цас их орж хайлах үргэлжилсэн бороо орох зэрэг үед эдгээр сайр нь бага зэрэг устай болох боловч бороо татрахад усгүй болно. Хур бороотой үед жижиг хонхор хотгор газарт жижиг нуурууд бий болох ба тэдгээр нь элс, булингартай усаар дүүрдэг. Хүн малын унданд бага гүнтэй, гар худгийн ус хэрэглэх бөгөөд худгуудыг голчлон хуурай сайр, нуурын зах хөвөөг бараадуулан гаргасан байдаг. Худгийн түвшин нь 5-6 м-т заримдаа 9-10 м-т хүрдэг.

Хөрс

Монгол орны ургамал, газарзүйн мужлалаар Алтайн уулархаг их мужийн ГовьАлтайн зүүн тойрогт багтах ба энэ талбайн хөрс нь Монгол орны байгалийн бүсийн хуурай хээр, заримдаг цөлийн бүсэд хамрагдана. Говийн цайвар бор хөрс, уулын цөлөрхөг хээрийн бор саарал хөрс, хужирлаг говийн бор саарал, цөлөрхөг хээрийн бор хөрс, уулын цөлийн бор саарал хөрс, цөлөрхөг хээрийн бор хөрс, элсэрхэг говийн бор хөрс зэрэг хэв шинжийн хөрс тархсан байна. Ургамлын хувьд Монгол орны ургамалгазарзүйн мужлалаар Өмнөговь аймаг нь Говь-Алтайн уулын цөлөрхөг хээр, Алшаа говь, Дорноговийн цөлөрхөг хээрийн тойрогт багтдаг. Ургамлын зүйлийн бүрдлийн 21.4% нь хуурайсаг, 21.3% нь хуурайсуу-чулуусаг, 15.5% нь чийгсүү-давссаг, 10.2% нь чийгсүү-хуурайсаг, 6.5% нь элсэн дасалттай ургамал бөгөөд сөөг, сөөгөнцөр ургамлын бүлгэмдэл зонхилно.



Ургамал зүй

Ургамлын хувьд Монгол орны ургамал-газарзүйн мужлалаар Өмнөговь аймаг нь Говь-Алтайн уулын цөлөрхөг хээр, Алшаа говь, Дорноговийн цөлөрхөг хээрийн тойрогт багтдаг. Ургамлын зүйлийн бүрдлийн 21.4% нь хуурайсаг, 21.3% нь хуурайсуучулуусаг, 15.5% нь чийгсүү-давссаг, 10.2% нь чийгсүү-хуурайсаг, 6.5% нь элсэн дасалттай ургамал бөгөөд сөөг, сөөгөнцөр ургамлын бүлгэмдэл зонхилно.

Амьтны аймаг

Амьтдын хувьд Өмнөговь аймгийн нутаг дэвсгэр нь амьтны аймгийн газарзүйн мужлалаар Хойт говь, Говь-Алтай, Алтайн өвөр говийн тойрогт багтана. Уг нүүрсний орд орчмын газар нутагт том хөхтөнөөс Янгир ямаа, хавтгай тэмээ тэмдэглэгдсэн байна. Жижиг хөхтөн, хоёр нутагтан ба мөлхөгчид зэрэг зарим амьтдын зүйлийн бүрдлийг харвал Цөлийн хөхтөний бүлгэмдлээс Боролзон туулай, Элсээг зузга, Бордуу шишүүхэй, шаргал чичүүл, морин цөцүүл, шивэр алагдаага, Өмнөговийн алагдаага, Элсч савгадаахай, Гувруу тажигдаахай зэрэг амьтад байна.

Уур амьсгал

Нутгийн хойт хэсгээр Хангай, Говь-Алтайн уулсын нөлөө, өмнөд хэсгээр говийн нөлөө мэдэгдэхүйц байдаг. Уур амьсгалын хувьд нэн хуурай, дулаавтар, Говь-Алтайн цөлөрхөг хээрийн мужид хамрагдах бөгөөд агаарын жилийн дундаж температур 2-4°C, сүүлийн 3 жилийн дунджаар 2.6-4.2°C болсон нь олон жилийн дундажаас харьцангуй өндөрт тооцогдоно. Олон жилийн дундаж салхины хурд 3-5 м/с, сүүлийн жилүүдийн салхины дундаж хурд 4-6 м/с болж, 15 м/с- ээс дээш салхитай өдрийн тоо жилд 15-20, хамгийн их салхины хурд 40 м/с хүрдэг. Агаарын үнэмлэхүй их температур +45°C-аас их, үнэмлэхүй бага температур - 40°C-аас хүйтэн болох нь бий. Зун нь аагим халуун, өвөл нь цас бага дулахан хуурай байдаг. Агаарын жилийн дундаж температур +4°C-аас +6°C хамгийн их халуун нь 7 сард +38°C-аас +40°C-д хүрч халдаг. Тус сумын нутагт дулааны хангамж сайтай, жилийн цэлмэг өдрийн тоо 120-150 өдөр, жилд нар гийгүүлэх хугацаа 3200 орчим цаг байдаг. Харин чийгийн хэмжээ бага, жилд орох хур тундасны хэмжээ олон жилийн дунджаар 50-110 мм байсан бол сүүлийн жилүүдэд энэ хэмжээ багасаж дунджаар 60100 мм тунадас орох ба үүний 70- 80% нь 7-8 сард унана. Жилийн хамгийн халуун сар нь 7 дугаар сар буюу дунджаар +21.9°C дулаантай бол жилийн хамгийн хүйтэн сар нь 1 дүгээр сар буюу дунджаар -11.3°C хүйтэн байна. Жилийн температурын зөрүү нь 33.2°C. Жилийн хамгийн намдуу буюу салхи багатай сар нь зун, өөрөөр хэлбэл 7 дугаар сар хамгийн бага салхитай байна. Салхины зонхилох чиглэл нь баруун болон баруун хойд зүгээс байна.

2.2. Нийгэм, эдийн засаг

Өмнөговь аймгийн ИТХ-ын 2020 оны 12 дугаар сарын 03-ны өдрийн 2/3 дугаар тогтоолоор баталсан аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлд эдийн засгийн тогтвортой, хүртээмжтэй, олон тулгуурт бүтэцтэй, ажлын байр нэмэгдэж, ажилгүйдэл буурсан, төсвийн биеэ даасан байдлыг бэхжүүлж, байгальд ээлтэй үйлдвэрлэл, экспорт эрчимжсэн, хөрөнгө оруулалт хуримтлалын чадавхаа дээшлүүлсэн Говийн бүсийн тулгуур төв болгон хөгжүүлнэ гэж тодорхойлжээ. Үүнд хүрэхэд уул уурхайн үйлдвэрлэл тэр дундаа нүүрсний уурхайнуудын үйл ажиллагаа голлох байр суурийг эзэлнэ.

Тус аймагт 12 төрлийн ашигт малтмалын 71 орд, 185 орчим илрэл тэмдэглэгджээ. Орон нутагт ашигт малтмалын хайгуул судалгаа, олборлолтын үйл ажиллагаа явуулах хөрөнгө оруулагчдын тоо 1997 оноос хойш тасралтгүй өсөж ирсэн.

2022 оны 12 сарын байдлаар тус аймгийн нутаг дэвсгэрт ашигт малтмалын 156 тусгай зөвшөөрөл хүчин төгөлдөр байгаагаас 107 нь ашиглалтын, 49 нь хайгуулын зөвшөөрөл байгаа ба эдгээр нь нийт нутаг дэвсгэрийн 5 хувийг эзэлж байна. Аймгийн эдийн засгийн нэг гол салбар нь хөдөө аж ахуй, үүний дотор мал аж ахуй голлох хувийг эзэлдэг. Статистикийн мэдээллийн сангийн 2021 оны мэдээгээр Ноён сум 110.35 мянган толгой малтай. Үүнд 10.46 мянган толгой буюу 9.5%-ийг хонь, 89.7 мянган толгой буюу 81.3%-ийг ямаа, 2.5 мянган толгой буюу 2.3%-ийг адуу, 0.34 мянган толгой буюу 0.3%-ийг үхэр, 7.4 мянган толгой буюу 6.7%-ийг тэмээ тус тус эзэлж байна. Эдгээр нь 355 малтай өрхөд хамаарах ба үүнийг 491 малчин адгуулан маллаж амьдарч байна.

Ноён сумын нутаг дэвсгэрт одоогийн байдлаар “Терра Энержи” ХХК болон “Хур Эрдэнэ Баялаг” ХХК нүүрс олборлож Шивээхүрэн боомтоор БНХАУ-д экспортлон гаргадаг бөгөөд орон нутгаас ажиллах хүч, худалдан авалт хийх болон жил бүр орон нутагтай хамтран ажиллах гэрээний хүрээнд багагүй хэмжээний мөнгөн болон бусад дэмжлэг үзүүлдэг. Сумын төвд хүн эмнэлэг, мал эмнэлэг, мэдээлэл холбооны салбартай, дунд сургуультай, шатахуун түгээх станцтай, төсөвт байгууллага, арилжааны 2 банк зэрэг 20 орчим аж ахуйн нэгж, албан байгууллага үйл ажиллагаа явуулж байна¹.

¹ Өмнөговь аймгийн Ноён сумын нутагт орших “Баруун ноён уул”-ын чулуун нүүрсний ордыг ил аргаар ашиглах Техник, эдийн засгийн үндэслэлийн тодотгол I, 2023 он

ГУРАВ. ТӨСЛӨӨС ҮЗҮҮЛЖ БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛӨЛ

“Хур эрдэнэ баялаг” ХХК-ний “Баруун ноён уулын чулуун нүүрсний ордыг ил аргаар ашиглах” төслийг хэрэгжүүлснээр байгаль орчны төлөв байдалд үзүүлж болзошгүй нөлөөллийг “Магадлан жагсаах” арга болон экспертийн үнэлгээний Матрицын аргыг хослуулан тодорхойлсон.

Магадлан жагсаах арга нь нөлөөлөх зүйл байгаа-байхгүй гэсэн зарчим дээр үндэслэж, сөрөг нөлөөллийг “х”-ээр, эерэг нөлөөллийг “+”-ээр тэмдэглэдэг. Нөлөөллийн хэлбэр, үргэлжлэх хугацаа, эрчмийг илрүүлэхэд зориулагдсан бөгөөд нөлөөлөл нь шууд, шууд бус, буцах ба буцалтгүй, давхардах эсэхийг тодруулах, хугацааны хувьд урт, богино, эрчмийн хувьд хүчтэй эсэхийг үзүүлсэн.

Хүснэгт 3.1. Байгаль орчинд үзүүлэх нөлөөллийн хэлбэр үргэлжлэх хугацаа

№	Байгаль орчны үзүүлэлт	Шууд	Шууд бус	Өөрөө зохицуулагдах	Богино хугацааны	Урт хугацааны	Буцаж нөлөөлөх	Буцалтгүй нөлөөлөх	Сулавтар нөлөөлөх	Дунд зэрэг нөлөөлөх	Хүчтэй нөлөөлөх
1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12
1. Байгалийн төрөл зүйн өөрчлөлт											
1	Газрын доорх урсацын өөрчлөлт	-				-	-			-	
2	Газрын доорх усны чанарын өөрчлөлт		-	-					-		
3	Ургамлын бүтцийн өөрчлөлт	-				-	-			-	
4	Хөрсний элэгдэл, эвдрэл	-				-			-		-
5	Геологийн тогтоцын өөрчлөлт	-				-			-		-
6	Зэрлэг, ан амьтдын орон зайн өөрчлөлт		-	-					-		
7	Уур амьсгалын (бичил) өөрчлөлт			-					-		
2. Байгалийн нөөцийн ашиглалт											
8	Газрын гадаргын нөөц баялаг	-				-			-		
9	Бэлчээр, тэжээлийн байдал	-		-			-		-		
10	Эрдэс түүхий эд, нөөц	-				-			-		-
11	Эрчим хүчний нөөц										
3. Байгаль орчны чанарын өөрчлөлт											
12	Ундны усны чанар өөрчлөгдөх		-	-	-			-		-	
13	Ундны усны нөөц хомсдох		-	-						-	
14	Агаарын бохирдол	-			-					-	
15	Хөрсний бохирдол		-		-		-			-	
16	Хорт бодис усаар дамжин хүн, амьтанд үзүүлэх нөлөөлөл		-			-	-			-	
17	Дуу, чимээ шуугианы нөлөөлөл	-			-				-		
4. Байгалийн өнгө төрх, түүх соёлын дурсгалт зүйл, археологи, палентологийн олдвор											
18	Байгалийн үзэсгэлэнт төрх өөрчлөгдөх		-			-			-		
19	Ландшафтын хэлбэр, өнгө өөрчлөгдөх		-			-	-			-	

Өмнөговь аймгийн Ноён сумын нутагт байрлах “Баруун ноён уул” уурхайн 2024 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөө

20	Тусгай хамгаалалттай газар, нутагт нөлөөлөх									
21	Түүх соёлын дурсгалт зүйлд нөлөөлөх									
22	Археологи, палентологийн олдворт нөлөөлөх									
5. Нийгэмд үзүүлэх нөлөөлөл										
23	Дэд бүтцийн хөгжилд нөлөөлөх		+			+		+		+
24	Үйлчилгээний салбарын үйл ажиллагаанд нөлөөлөх		+			+				+
25	Хүн амын орлого нэмэгдэж өөрчлөгдөх	+				+		+		+
26	Хүн амын тоо өөрчлөгдөх		-			-			-	
6. Эдийн засаг, байгаль орчин										
27	Хувийн өмчийн болон татварын орлого өөрчлөгдөх									
28	Орон нутгийн орлого нэмэгдэх	+				+		+	+	
29	Ядуурлыг бууруулахад дэмжлэг болох	+				+		+	+	
30	Ажлын байр нэмэгдэх	+				+		+	+	
31	Улирлын чанартай эрэлт хэрэгцээ нэмэгдэх	+			+				+	
32	Хүн амын эрүүл мэндэд нөлөөлөх									
7. Бусад нөлөөлөл										
33	Шороон зам харилцаа, уурхайн машин механизмын хөдөлгөөн шилжилтээс үүдэх хөрсний эвдрэл	-				-		-		-
34	Ахуйн бохир ус, нефтийн бүтээгдэхүүн хөрсөнд нэвчиж хөрс ба грунтны усыг бохирдуулах	-			-				-	
35	Ахуйн хог, хаягдал, хогийн цэгийн ариутгал муугаас эвгүй үнэр гарах, шавьж үржих	-			-		-		-	
36	Хүчтэй салхи, тоосжилт	-			-					

Тайлбар: +/- Эерэг нөлөөлөл
/-/- Сөрөг нөлөөлөл

Дээрхи үнэлгээнээс үзэхэд төслийн үйл ажиллагаанаас байгаль орчин, нийгэм, эдийн засагт үзүүлэх нийт нөлөөллийн тоо нь гол болон болзошгүй сөрөг нөлөөлөл нь 22 байна. Үүнээс:

Шууд нөлөөлөл: Энд шууд үйлчлэх нөлөөлөл 17 байгаа бөгөөд эдгээрт нүүрс олборлох үйл ажиллагааны улмаас газрын доорх урсацанд өөрчлөлт орох, хөрсний элэгдэл эвдрэл үүсэх, геологийн тогтоц өөрчлөгдөх, ашигт малтмалын нөөц хомсдох, агаарын бохирдол үүсэх, ургамлан нөмрөг талхлагдах, бэлчээрийн даац багасах, хүчтэй салхи тоосжилт үүсэх гэх мэт сөрөг нөлөөлөл бий болж байна.

Шууд бус нөлөөлөл: Нөлөөллийн энэ ангилалд 12 зүйлийн нөлөөлөл хамаарч байна. Үүнд: Газрын доорх усны нөөц болон чанар өөрчлөгдөх, ургамлын бүтцийн өөрчлөлт, зэрлэг амьтдын орон зайн өөрчлөлт, хөрсний бохирдол, байгалын үзэсгэлэнт төрх өөрчлөгдөх, хүн амын шилжилт явагдах зэрэг сөрөг нөлөөллүүд байна.

Өөрөө зохицуулагдах нөлөөлөл: Энд өөрөө зохицуулагдах 6 болзошгүй нөлөөллөөс газрын доорх ус болон чанар өөрчлөгдөх, зэрлэг ан амьтны орон зайн өөрчлөлт, уур амьсгалын өөрчлөлт, бэлчээр тэжээлийн байдал зэрэг багтаж байна.

Удаан хугацааны нөлөөлөл: 16 зүйлийн удаан хугацааны нөлөөлөл байгаагийн дотор газрын доорх урсацын өөрчлөлт, ургамлан нөмрөг өөрчлөлт, хөрсний элэгдэл, эвдрэл үүсэх, геологийн тогтоц өөрчлөгдөх, ашигт малтмал, газрын гадарга, эрдэс түүхий-эдийн нөөц хомсдох, хорт бодис усаар дамжин хүн амьтанд үзүүлэх нөлөөлөл, байгалийн үзэсгэлэнт төрх өөрчлөгдөх, ландшафтын хэлбэр, өнгө өөрчлөгдөх, шороон зам харилцаа, уурхай машин механизмын хөдөлгөөн шилжилтээс болж хөрс эвдрэх зэрэг сөрөг нөлөөллүүд багтаж байна.

Богино хугацааны нөлөөлөл: Ийм хэлбэрийн нөлөөлөлд 9 зүйлийн нөлөөлөл орж байна. Үүнд: ундны усны горим, нөөц, чанар, агаарын бохирдол хөрсний бохирдол, дуу чимээ шуугианы нөлөөлөл, хүн амын шилжилт, ахуйн бохир ус, нефтийн бүтээгдэхүүн хөрсөнд нэвчих зэрэг сөрөг нөлөөллүүд орж байна.

Буцаж нөлөөлөх: Энд 7 зүйлийн нөлөөлөл багтаж байгаагийн дотор газрын доорх урсацын өөрчлөлт, ургамлын бүтцийн өөрчлөлт, бэлчээр тэжээлийн байдал, хөрсний бохирдол, хорт бодис усаар дамжин хүн, амьтанд үзүүлэх нөлөөлөл, ландшафтын хэлбэр өнгө өөрчлөгдөх зэрэг болзошгүй сөрөг нөлөөллүүд багтана.

Буцалтгүй нөлөөлөл: Энэ төрлийн нөлөөлөлд 11 зүйлийн нөлөөлөл хамаарч байна. Энэ нь нүүрс олборлох үйл ажиллагааны улмаас хөрсний бүтэц, орд газрын геологийн тогтоц, нүүрсний хэмжээ багасан хомсдох зэрэг болзошгүй сөрөг нөлөөллүүдээс гаднадэд бүтэц хөгжих, хүн амын орлого нэмэгдэх, ажлын байр нэмэгдэх, ядуурал буурах зэрэг нь нийгэм, эдийн засгийн салбарт эергээр нөлөөлөх юм.

Хүчтэй нөлөөлөл: Энэ төрлийн нөлөөлөл 3 байгаа бөгөөд нүүрс олборлох үйл ажиллагааны улмаас хөрсний бүтэцэд өөрчлөлт орох, нүүрсний нөөцийн хэмжээ багасах, орд газрын геологийн тогтоц өөрчлөгдөх зэрэг хүчтэй нөлөөлөл гарч болзошгүй гэж үзэж байна.

Дунд зэргийн нөлөөлөл: Нөлөөллийн энэ ангилалд 10 зүйлийн нөлөөлөл орж байна. Үүнд: орд газарт байгалийн хөрс үгүй болж, орчны ургамал нөмрөг талхлагдан, бэлчээрийн талбай багасах, агаар бохирдох, ан амьтдын тархалт, тоо толгой өөрчлөгдөх зэрэг байгаль орчинд үзүүлэх болзошгүй сөрөг нөлөөллүүдийн зэрэгцээ, орон нутгийн орлого, орон нутгийн дэд бүтцийн хөгжил, хүн амын орлого нэмэгдэх зэрэг эерэг нөлөөллүүд хамрагдана.

Сулавтар нөлөөлөл: Сулавтар нөлөөллийн тоонд 16 зүйлийн нөлөөлөл орж байгаа бөгөөд нүүрс олборлох үйл ажиллагааны улмаас уулын чулуулгийн тогтоц, газрын доорх усны горим, хэмжээ, чанар өөрчлөгдөх, уур амьсгалын бичил өөрчлөлт, ан амьтдын орон зайн өөрчлөлт, дуу чимээ, шуугианы нөлөөлөл, хүн амын тоо өөрчлөгдөх сөрөг нөлөөллүүд байна.

Гол сөрөг нөлөөллийн үнэлэлтийн нарийвчилсан үнэлгээний дээрх хүснэгтээс үзэхэд нөлөөлөлд өртөгч экологийн орчин нь нүүрсний орд газрын хөрс, эрдэс баялаг, ургамлан нөмрөг, бэлчээр, орчны агаар, бичил уур амьсгал бөгөөд эдгээр хамгийн их нөлөөлж болзошгүй үйл ажиллагаа нь хөрс хуулалт, нүүрс олборлолт, тээвэрлэх үйл ажиллагаа, машин техникийн дуу чимээ, доргио зэрэг болно.

ДӨРӨВ. 2024 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Зорилго, зорилт: Өмнөговь аймгийн Ноён сумын нутагт Баруун Ноён Уул нүүрсний ордын ашиглалтын үйл ажиллагааны Байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээ 2018, 2024 онуудад батлагдсан тайлангуудын хүрээнд тогтоогдсон төслийн үйл ажиллагаанаас байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний хэрэгжилтийг хангаж ажиллах үндсэн зорилготой.

2024 онд байгаль орчныг хамгаалах, сөрөг нөлөөллийг бууруулах чиглэлээр нэн тэргүүнд тавих зорилтот ажлууд нь компаний байгаль орчны бодлого удирдлагын тогтолцоог бий болгох, хог хаягдлын менежментийн сайжруулах ажлуудыг зорилт болгон ажиллана.

Хамрах хүрээ: Байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд 2024 оны Баруун Ноён Уул ордын ашиглалтын үйл ажиллагааны бүх үе шатыг хамарна. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг нь “Байгаль орчныг хамгаалах тухай”, “Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай” хуулиуд, Монгол улсын Засгийн газрын 2013 оны 374 дүгээр тогтоолоор баталсан “Байгаль орчны нөлөөллийн үнэлгээний журам”, БОАЖЯ-ны сайдын 2019 оны 10-р сарын 29-ний өдрийн А-618 журмын 3 дугаар хавсралтаар баталсан “Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам”-уудыг тус тус баримталснаас гадна байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний үр дүнд тулгуурласан болно.

4.1. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө

4.1.1. Агаар орчны сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө

Хүснэгт 4. 1. Агаар орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө

№	Гол болон болзошгүй	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих	Нэгжийн зардал, мян.төг	Тоо хэмжээ	Нийт зардал, мян.төг	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1	Агаарын чанар	Замын тоосжилтыг бууруулах зорилгоор усалгаа хийх (дулааны улиралд усалгааг тогтмол хийх)	Уурхайн технологийн зам, туслах зам, нүүрс агуулах талбай;	тн/км	99.74	236	23538.64	Тогтмол	Монгол улсын Агаарын тухай хууль MNS4585:2016 Агаарын чанарын стандарт-Техникийн ерөнхий шаардлага
		км		1500	1	1500	Тогтмол		
		Замгаас үүсэх тоосжилтыг бууруулах - хурдны хязгаарыг дагаж мөрдүүлнэ. (шаардлагатай бол хурдны хязгаарын тэмдэг, тэмдэглээ байрлуулах)	Уурхайн технологийн зам, туслах зам, нүүрс агуулах талбай;	км	500	--*--	500	Улиралд нэг удаа	
		Ажилчдыг эрүүл ажиллах, амрах орчинг бүрдүүлэх зорилгоор уурхайн тосгоны ногоон байгууламжийг нэмэгдүүлэн, тоосжилтоос хамгаалан зүлэгжүүлэх;	Уурхайн тосгон;	м ²	5302.18	1	5302.18	Нэг удаа	
2	Нийт мян.төг								30840.82

4.1.2. Гадаргын ба газрын доорхи усны нөөцөд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө

Хүснэгт 4. 2. Усны нөөцөд учруулж болзошгүй сөрөг нөлөөг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал, мян.төг	Тоо хэмжээ	Нийт зардал, мян.төг	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1	Ил уурхайн гүн доошлохын хэрээр усны шүүрэлт ихсэж, уурхайгаас зайлуулах усны хэмжээ нэмэгдэж газрын доорх ус хомсдох; Тоосжилт бууруулах хэрэглээнээс төслийн талбай, түүний орчмын газрын доорх усны түвшин буурах; Ахуйн шингэн хаягдал болон нефтийн бүтээгдэхүүн алдагдсаны улмаас хөрсний ус бохирдох	Уурхайн ундны усны хэрэглээг тогтмол бүртгэх, ашиглах усны хэмжээг зорилгод түвшинд байлгах;	Уурхайн тосгон;	м ³	0.0997	Баталгаажуулсан усны тоолуурын заалтаар	538.38	Тогтмол	MNS0900:2018 Хүрээлэн буй орчин, Эрүүл мэндийг хамгаалах. Аюулгүй байдал. Ундны ус. Эрүүл ахуйн шаардлага, чанар аюулгүй байдлын үнэлгээ” - MNS4943:2015. Хүрээлэн байгаа орчин. Усны чанар, хаягдал ус. Ерөнхий шаардлага”
		Уурхайн ногоон байгууламж усалгаанд зориулж ус ашиглах;	Уурхайн хэсэг;	м ³	0.79794		2659.8	2, 3-р улирал	
		Усны зохистой ашиглалтын талаар сургалт явуулах	Уурхайн нийт ажилчид	Сургалтанд хамрагдсан ажилчидын тоогоор, мэдээллийн хуудас, гараах материалын тоо	100	2	200	Хагас жил тутам, Шинээр ажилд орж буй бүх ажилчид сургалтад хамрагдах	
		Усыг үр ашигтай хэрэглэх талаар ухуулга, сурталчилгааг ажилчдад хийх, мэдээллийн хуудсыг зарын самбарт байрлуулж шинэчилж байх			100	Тодорхой лох боломжгүй	100	Үйл ажиллагааны туршид	
		Уурхайн карерт шүүрч буй усыг тогтмол шавхаж зам талбайн тоосжилтыг	Уурхайн үйл ажиллагааны хүрээнд	м ³	*	3	*		

		багасгах зорилгоор ашиглах								
2	Нийт мян.төг									3498.18

4.1.3. Хөрсөн бүрхэвчид учруулж болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө

Уурхайн хаалтын нөхөн сэргээлтэд стратегийн чухал ач холбогдол бүхий шимт болон шимэрхэг хөрсийг хамгаалах хөрсийг зөв хуулах, хадгалах, чанарын үзүүлэлтүүдийг хянах зэрэг шаардлагуудыг ханган, хөрсөн бүрхэвчид учруулж болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулахад дараах арга хэмжээнүүдийг авч ажиллана.

Хүснэгт 4. 3. Хөрсөн бүрхэвчид үзүүлж болзошгүй сөрөг нөлөөг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал, мян.төг	Тоо хэмжээ	Нийт зардал, мян.төг	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг	
